



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/13

Шивээговь сум

Ажлын хэсэг томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 95 дугаар тогтоол, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Сумын 2020 оны төсөв батлах тухай” 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2020 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжих “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн дарга:	Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
Гишүүд:	Орон нутгийн хөгжлийн сангийн нягтлан бодогч
	Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
Хөндлөнгийн төлөөлөл:	Сумын Ахмадын хорооны дарга

2. Дээрх хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Засаг даргын Тамгын газрын дарга/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

4212-0028